

БАНК ХООРОНДЫН ЗАХЫН ИДЭВХЖИЛ

Мөнгөний бодлогын хэлтсийн эдийн засагч Г. Бумчимэг

Үдиртгал

Банк хоорондын зах нь санхүүгийн байгууллагууд нөөцөө оновчтой удирдах, Төв банкнаас мөнгөний бодлого хэрэгжүүлэх, мөн санхүүгийн хэрэгслүүдийг хүүгээр хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Санхүүгийн байгууллагууд богино хугацаанд илүүдэл нөөцөө зохистой байршуулах, нөөцийн дутагдлаа нөхөх асуудлаа банк хоорондын мөнгөний захын тусlamжтайгаар шийддэг. Нөөцийн дутагдалтай банк хэрэгцээт мөнгөн хөрөнгөө олж авахын тулд банк хоорондын арилжаанд оролцдог бол илүүдэл нөөцтэй банк хөрөнгөө илүү ашигтайгаар байршуулах сонирхлын үүднээс арилжаанд оролцдог. Тухайлбал, Заавал байлгах нөөц /ЗБН/-ийн шаардлагыг хангаагүй банк нь ТБҮЦ-ны арилжаанд оролцох боломжгүй бөгөөд энэ тохиолдолд банк хоорондын зах /БХЗ/-аас богино хугацааны санхүүжилт авч арилжаанд оролцох жишээтэй. Үүнтэй адил аар валютын нөөцийг ч худалдан авч болно. Иймээс БХЗ-ын хөгжил нь санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмждэг.

БХЗ нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ чухал ач холбогдолтой. Төв банк нь банкны салбарын нөөцөд нөлөөлөн улмаар эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээг удирддаг. БХЗ дээр банкууд нөөцөө удирдах чадвар сайтай байх нь Төв банк мөнгөний бодлогоо илүү нарийн явуулж байгааг илэрхийлнэ.

Банк хоорондын захын арилжааны жигнэсэн дундаж хүү нь санхүүгийн хэрэгслүүдийг хүүгээр хангадаг.

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь БХЗ-ын үйл ажиллагааг судалж, түүнийг цаашид хөгжүүлэх боломжийг илрүүлэхэд оршино. БХЗ-ын мэдээг банкуудаас 2002 оны 11-р сараас эхлэн авсан учраас БХЗ-ын шинжилгээг энэ үеэс эхлэн хийллээ.

Монголын банк хоорондын захын талаар

БХЗ дээр төгрөгийн болон валютын зээл, Төв банкны үнэт цаас /ТБҮЦ/, Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/, репо, овернайт зээлийн арилжаанууд хийгддэг. Дээрх захын хэлцлүүд нь бүгд богино хугацааны арилжаанууд байдаг.

Монголбанкнаас БХЗ-д нөлөөлөх бодлогын хэрэгслийг нэрлэвэл:

- Заавал байлгах нөөц,
- ТБҮЦ-ны арилжаа,
- Монголбанкнаас банкинд олгох санхүүжилт (репо, овернайт, хямдруулалтын санхүүжилт),
- Валютын арилжаа зэрэг болно.


Эдгээрийн нөлөөллийг дэлгэрэнгүй авч үзье. Үүнд:

Заавал байлгах нөөц

Заавал байлгах нөөцийн хэмжээг сар бүрийн 15-ны өдөр болон эцсийн өдөр сард 2 удаа тогтоодог. Банкуудын Төв банк дахь харилцахын дүн нь өссөн дүнгээрээ ЗБН-ийн шаардлагаас бага байвал мөнгөн торгууль ногдуулдаг. Монголбанкнаас ЗБН-ийг хангаагүйд ноогдуулах торгуулийн дээд хязгаар нь тухайн үед Монголбанкнаас банкинд олгох хамгийн өндөр хүү¹тэй зээлийн хүү дээр 5 нэгж хувийг нэмнээс илүүгүй байна.

Банкуудын нөөц нь ЗБН-ийг биелүүлсэн хэсэг болон илүүдэл нөөцийн нийлбэр /Банкуудын нөөц=ЗБН+илүүдэл нөөц/ учраас ЗБН-ийн хэмжээ нь илүүдэл нөөцөд шууд нөлөөлдөг. ЗБН болон илүүдэл нөөцийн сарын дунджийг үзүүлсэн графикаас харахад 2003 оны 4 дүгээр сараас эхлэн илүүдэл нөөц харьцангуй бага болсон байна /Зураг 1, Зураг 2/.

Зураг 1. ЗБН-ийн хангальт




Жил бүрийн эхний улиралд зээлийн эргэн төлөлт их, зээл олголт харьцангуй бага байдагтай холбоотойгоор энэ хугацаанд банкуудын илүүдэл нөөц их байдаг.

¹ Банкинд олгох зээлийн хамгийн өндөр хүү нь овернайт зээлийн хүү бөгөөд овернайт зээлийн хүүг ТБҮЦ-ны хамгийн өндөр хүү дээр 5 нэгж хувийг нэмэн тогтоодог.

Илүүдэл нөөц бага байх нь БХЗ идэвхжиж, банкуудын нөөцөө удирдах чадвар сайжирч байгааг илтгэдэг. Илүүдэл нөөцийн өдөр бүрийн дундаж үлдэгдлийг графикаар харуулбал 2004 оны 7 дугаар сард хэлбэлзэл харьцангуй өндөр байгаа нь төгрөгийн ам.доллартай харьцах ханшны хэлбэлзэл өндөр байсантай холбоотой /Зураг 2/.


Зураг 2. Илүүдэл нөөц



Төв банкны үнэт цаас


ТБҮЦ нь 1993 оноос эхлэн мөнгөний зах зээлийн гол хэрэгсэл болсоор ирсэн. ТБҮЦ мөнгөний бодлогын хэрэгжилтэд чухал ач холбогдолтойгоос гадна банкуудын илүүдэл нөөцөө байршуулах, ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа нь БХЗ-ын гол хэрэгсэл болдог. Банкуудын эзэмшиж буй ТБҮЦ-ны өдөр бүрийн хэмжээ, жигнэсэн дундаж хүүг графикаар харуулбал хэмжээ нь харьцангуй тогтвортой хэдий ч хүүг тогтвортгүй байна /Зураг 3/.

Зураг 3. ТБҮЦ



Монголбанк нөөц мөнгөний хэмжээг завсрын гол зорилтоо болгодог. Нөөц мөнгөний хэмжээг ТБҮЦ-аар дамжуулан удирдахдаа түүний зарласан хүү, хэмжээг өөрчилж банкуудын нөөцдөд нөлөөлдөг.


Зураг 4. БХЗ-ын, ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү (жилээр)



Дээрх зургаас харахад БХЗ-ын жигнэсэн дундаж хүү нь ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүүтэй бараг ижил байгаа нь БХЗ-ын арилжаанд ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа², репо хэлцэл³ ихэнх хувийг эзэлж байгаатай холбоотой.


БХЗ-ын арилжааны бүтцээс харахад 2002 оны 11 дүгээр сараас 2004 оны 8 дугаар сар хүртэлх нийт арилжааны 87.3 хувийг ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа, репо хэлцэл эзэлж байна /Зураг 5/.

Зураг 5. БХЗ-ын арилжааны бүтэц



БХЗ дээрх сүүлийн жилүүдэд гарсан хөдөлгөөнийг ажиглавал 2004 оны 2 дугаар сард БХЗ-ын арилжаа огцом өсч 95.6 тэрбум төгрөгт хүрчээ /Зураг 6/.

Зураг 6. БХЗ-ын арилжаа




² ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа гэдэг нь А банк Б банкинд эзэмшиж буй ТБҮЦ-аа зарахыг хэлнэ.

³ ТБҮЦ-ны репо хэлцэл гэдэг нь тохиролцсон хугацааны эцэст зээлдэгч банк өмнө нь худалдсан байсан ТБҮЦ-аа урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдан авах хэлцэл юм.

Энэ нь тухайн үед Худалдаа хөгжлийн банкинд шаардагдсан 72.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээс болсон бөгөөд түүнийг 8 банк санхүүжүүлсэн байна. Энэ нь БХЗ-ын арилжаанд том банкууд чухал нөлөөтэй болохыг харуулж байна.

2004 оны 8 дугаар сарын байдлаар банкуудын нийт актив, БХЗ дээрх 2002 оны 11 дүгээр сараас 2004 оны 8 дугаар хүртэлх нийт арилжааны дүнг харьцуулбал актив өндөртэй банкууд арилжаанд түлхүү оролцдог байна /Зураг 7/.

Зураг 7. Банкуудын нийт актив болон БХЗ-ын арилжаа



Зарим жижиг банкуудын хувьд ЗБН-ийн тогтоосон хэмжээ нь өдөр тутмын харилцаад шаардлагатай мөнгөнөөс хэтэрдэггүй учраас илүүдэл нөөцийн оновчтой хуваарилалтад санаа зовдоггүй, шаардлага ч байдаггүй байна.

Монголбанкнаас банкинд олгох санхүүжилт

БХЗ-ыг идэвхжүүлэхэд банкуудын Төв банкнаас авах санхүүжилтийг бууруулах нь чухал ач холбогдолтой.

Монголбанк эцсийн зээлдэгчийн хувьд банкуудад дараахь төрлийн санхүүжилтийг олгодог: хямдруулалтын санхүүжилт⁴, репо санхүүжилт⁵, овернайт зээл⁶.


Монголбанкнаас 2003 онд 108.5 тэрбум төгрөгийн, 2004 оны эхнээс 8 дугаар сарыг дуустал 136.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хөдөө аж ахуй, Худалдаа хөгжил, Монгол шуудан, Голомт, Аюл, Хадгаламж, Улаанбаатар хотын болон Зоос банкуудад олгожээ. Монголбанкнаас олгосон санхүүжилтийн ихэнх хувийг овернайт зээл эзэлж байна /Зураг 8/.

Зураг 8. Монголбанкнаас 2003, 2004 онд банкуудад олгосон санхүүжилт

⁴ Хямдруулалтын санхүүжилт гэдэг нь банкинд богино хугацааны нөөцийн дутагдал, санхүү, төлбөрийн чадварын доголдол гарч, БХЗ-аас эх үүсвэр олоогүй тохиолдолд Монголбанкнаас банкны эзэмшиж буй ТБҮЦ, ЗГҮЦ, Монголбанкнаас зөвшөөрсөн бусад активыг хямдруулан худалдан авч тухайн банкийг санхүүжүүлэхийг хэлнэ.

⁵ Монголбанкны репо санхүүжилт тохиролцсон хугацааны эцэст зээлдэгч банк өмнө нь худалдсан байсан өөрийн эзэмшилийн активаа урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдаж авах, Монголбанк нь буцаан худалдаа хэлбэрээр хийгдэнэ.

⁶ Овернайт зээл гэдэг нь банк хоорондын клирингийн гүйлгээ хаахаас дараагийн ажлын өдрийн клирингийн гүйлгээ нээх хүргэл хугацаанд Монголбанкнаас банкинд зээл олгохыг хэлнэ.



Монголбанкнаас 2004 онд олгосон санхүүжилтийн ихэнх хэсгийг Худалдаа хөгжил (57.5 тэрбум төгрөг), Анод (35.0 тэрбум төгрөг) болон Хөдөө аж ахуйн банк (25.4 тэрбум төгрөг) авчээ /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. 2004 онд банкинд олгосон санхүүжилт (банк тус бүрээр)


Банкууд	Санхүүжилтийн төрөл			Дүн
	Овернайт зээл	Репо санхүүжилт	Хямдруулалтын санхүүжилт	
ХХБ	24000	23500	10000	57500
Анод	35000	0	0	35000
ХАА	8000	14500	3000	25500
Монгол шуудан	7600	0	0	7600
Голомт	0	4000	0	4000
Хадгаламж	2500	0	0	2500
Зоос	2400	0	0	2400
Улаанбаатар	1000	600	0	1600
Дүн	80500	42600	13000	136100

ТБҮЦ-ны хямдруулалтын санхүүжилтээр Хөдөө аж ахуйн болон Худалдаа хөгжлийн банкинд 2003 онд нийт 10.0 тэрбум төгрөгийн, 2004 оны эхнээс 8 дугаар сарыг дуустал нийт 13.0 тэрбум төгрөг олгожээ.

ТБҮЦ-ны репо санхүүжилтээр Хөдөө аж ахуй, Худалдаа хөгжил, Голомт, Хадгаламж, болон Улаанбаатар хотын банкинд 2003 онд нийт 34.3 тэрбум төгрөгийн, 2004 оны эхнээс 8 дугаар сарыг дуустал нийт 38.6 тэрбум төгрөг олгожээ.

Монголбанкнаас Хөдөө аж ахуй, Худалдаа хөгжил, Монгол шуудан, Голомт, Анод, Хадгаламж, Улаанбаатар хотын болон Зоос банкинд 2003 онд нийт 64.3 тэрбум төгрөгийн, 2004 оны эхнээс 8 дугаар сарыг дуустал нийт 80.5 тэрбум төгрөгийн овернайт зээлийг олгожээ. Овернайт зээлийн ихэнхийг 2003 онд Хөдөө аж ахуйн банк авч байсан бол 2004 онд дийлэнх хэсгийг Анод банк авчээ /Зураг 9/.


Зураг 9. Монголбанкнаас банкуудад олгосон овернайт зээл (банк тус бүрээр)



2004 оны 7 дугаар сараас өмнө Монголбанкнаас олгох овернайт зээлийн хүү нь ТБҮЦ-ны хамгийн өндөр хүүтэй тэнцүү байсан⁷. Монголбанкны овернайт зээлийн хүү харьцангуй бага байснаас арилжааны банкууд БХЗ-аас авах бололцоотой зээлийг Монголбанкнаас авч байжээ. Тухайлбал, 2004 оны эхний хагас жилд БХЗ дээр 22.5 тэрбум төгрөгийн овернайт зээлийг арилжаа хийгдсэн бол мөн үед Монголбанкнаас 70.1 тэрбум төгрөгийн овернайт зээлийг банкуудад олгосон байна. Энэхүү зээлийн ихэнхийг 4 дүгээр сард олгож энэ сард Монголбанкны овернайт зээлийн хүү 10.00 хувь, БХЗ-ын жигнэсэн дундаж хүү 12.26 хувь байснаас Монголбанк 44.1 тэрбум төгрөгийн овернайт зээлийг олгож, БХЗ дээр 4.7 тэрбум төгрөгийн овернайт зээлийн арилжаа хийгджээ.

2004 оны 7 дугаар сараас эхлэн Монголбанкнаас олгох овернайт зээлийн хүүг ТБҮЦ-ны хамгийн өндөр хүү дээр нэмэх 5 хувь болгосноор Монголбанкнаас авах овернайт зээлийн хүү БХЗ-ын овернайт зээлийн хүүгээс байнга өндөр болж Монголбанкны болон БХЗ-ын овернайт зээлд БХЗ-ын овернайт зээлийн эзлэх хувийн жин 2004 оны эхний хагас жилд 22.3 хувь байсан бол 3 дугаар улиралд БХЗ-ын овернайт зээлийн хувийн жин 55.4 хувь болон өсчээ /Зураг 10/.

Зураг 10. БХЗ дээр хийгдсэн, Монголбанкнаас банкуудад олгосон овернайт зээлийн хэмжээ, тэдгээрийн хүү (сар бүрээр)




⁷ 2004 оны 6 дугаар сард ТБҮЦ-н хамгийн өндөр хүү 15 хувь байсан.

Валютын арилжаа


БХЗ дээр Монголбанк, банкуудын хооронд валютыг худалдан авах, зарах арилжаа өргөнөөр хийгддэг боловч БХЗ дээр валютын зээл бага хийгддэг⁸. БХЗ дээр 2003 онд 112.1 сая ам.долларын, 2004 оны эхнээс 8 дугаар сарыг дуустал 72.4 сая ам.долларын арилжаа хийгджээ. Монголбанк 2003 онд банкуудаас 23.4 сая ам.долларыг худалдан авч, банкуудад 74.6 сая ам.долларыг зарсан бол 2004 оны эхнээс 8 дугаар сарыг дуустал банкуудаас 29.0 сая ам.долларыг худалдан авч, банкуудад 61.1 сая ам.долларыг зарсан байна /Зураг 11/.

Зураг 11. Монголбанкаас банкуудад зарсан ам.доллар (цэвэр дүнгээр)



Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хурдтай суларч буй үед ТБҮЦ-ны хүүнээс олох ашиг нь валютын ханшны зөрүүгээс олох ашгаас бага байна. Энэ үед банкууд нөөцөө гадаад валют хэлбэрээр байршуулах нь илүү ашигтай болдог. Тухайлбал, 2004 оны 7 дугаар сарын 1-нээс 7-ны өдрүүдийн хооронд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1174 төгрөгөөс 1180 төгрөг болж огцом суларснаар банкууд илүүдэл нөөцөөрөө ам.доллар худалдан авах болсон. Тухайн хугацааны банкуудын илүүдэл нөөц, Төв банк дахь валютын харилцах, худалдан авсан ТБҮЦ-ны хэмжээг Зураг 12, Зураг 13-т үзүүлэв.

Зураг 12. 7 сарын 1-нээс 14-ны хоорондох долларын ханшны хэлбэлзэл, валютын харилцах, илүүдэл нөөц




⁸ БХЗ дээр 2004 оны 1 дүгээр сард 150 мянган ам.долларын зээл олгогдсон ба бусад саруудад БХЗ дээр валютын зээл олгогдоогүй.

Сар, өдөр	Ханш	Ханшины суралт
7/1	1174	
7/2	1177	0.26%
7/3	1179	0.17%
7/6	1179	0.00%
7/7	1180	0.08%
7/8	1174	0.00%
7/9	1174	0.00%
7/14	1174	0.00%

Төгрөгийн ам.доллартай харьцах ханшины өсөлтийн түвшин 7 дугаар сарын эхний долоо хоногт ТБҮЦ-ны өдрийн хүү ($13.29\%/360=0.04\%$)-гээс өндөр байсан нь арилжааны банкуудын хувьд илүүдэл нөөцөөрөө ам.доллар худалдан авахыг илүү ашигтай болгосон.


7 дугаар сарын эхний 6 хоногт банкуудын төгрөгийн нөөцийн дутагдал дунджаар 3.9 тэрбум төгрөг болж өмнөх улирлын дунджаас 10.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Түүнчлэн Монголбанк дахь валютын харилцах дунджаар 31.3 тэрбум төгрөг болж өмнөх улирлын дунджаас 27 хувиар өсчээ. 7 дугаар сарын ТБҮЦ-ны анхны арилжааны дараа банкуудын эзэмшиж буй ТБҮЦ-ны хэмжээ 36.2 тэрбум төгрөг болж өмнөх долоо хоногийн хэмжээнээс 50.3 хувиар буурсан. ТБҮЦ хэлбэрээр байршиж байсан 36.7 тэрбум төгрөг банкуудад очсоноор 7 дугаар сарын 7-ноос ТБҮЦ-ны дараагийн арилжаа хийгдэх 14-ны өдөр хүртэл илүүдэл нөөц дунджаар 17.4 тэрбум төгрөг болж өссөн. Үүнийг Зураг 12 , Зураг 13-аас харж болох юм.

Зураг 13. 7 сарын 1-нээс 20-ны хооронд банкуудын эзэмшиж байсан ТБҮЦ



Энэ байдалд дүгнэлт хийн Монголбанк ТБҮЦ-ны зарласан хүүгээ нэмсэн бөгөөд банкуудын валютын эрэлтийг харгалзан ам.доллар чөлөөтэй зарж байсан. Энэ үеийн Монголбанкны ам.доллар худалдаж байсан ханш болон хэмжээг сонирхвол дараах байдалтай байна /Зураг 14/.

Зураг 14. 7 сарын 2-ноос 14-ны хоорондох ТБ-наас зарсан долларын хэмжээ, ханш



Монголбанкны дээрх үйл ажиллагааны үр дүнд ТБҮЦ-ны худалдан авалтыг 53.0 тэрбум болгон нэмэгдүүлж, ам.доллар луу хошуурах үзэгдлийг бууруулахад нөлөө үзүүлсэн.

Цаашдын боломж


БХЗ-ыг хөгжүүлэх боломжийг дурдахаасаа өмнө сайн хөгжсөн БХЗ ямар байхыг тодорхойлох нь зүйтэй юм. Сайн хөгжсөн БХЗ нь:

- БХЗ дээр арилжаа хийхэд хялбар байдаг,
- Үнийн дохиолол үйлчилдэг,
- Хүлээн зөвшөөрөгдсөн суурь хүүн дээр үндэслэдэг.

Дээрх шинж чанаруудыг бий болгохын тулд:

- *ЗБН-ийн тооцоонд Бямба, Ням гаригийг оруулахгүй байх*: ЗБН-ийн тооцоо нь банкуудын Монголбанк дахь харилцахын өдөр бүрийн дундаж үлдэгдлийг тогтоож өгдөг. Банкуудын Монголбанк дахь Баасан гаригийн харилцахын үлдэгдэл нь Бямба, Ням гаригийн харилцахын үлдэгдэл болж тооцогддог нь БХЗ дээр гажуудал үүсгэдэг. Энэ тооцооны улмаас банкууд Баасан гаригт харилцахаа өндөр байлгаснаар 1 өдрийнх биш 3 өдрийн харилцахын үлдэгдэл их гардаг. Энэхүү тооцоо нь банкуудын нөөцийг өссөн дүнгээр хийсвэрээр нэмэгдүүлдэг. Бямба, Ням гаригийн харилцахын үлдэгдлийг ЗБН-ийн тооцоонд оруулахгүй байх нь илүүдэл нөөцийн хэмжээг бодит байдлаар харуулна. Бямба, Ням гаригийг оруулалгүй тооцсон илүүдэл нөөц нь оруулан тооцсон илүүдэл нөөцөөс дунжаар 3.3 хувиар бага байна /Зураг 15/.

Зураг 15. Илүүдэл нөөцийн зөрүү (хувиар)



- *ТБҮЦ-ны программ хангамжсаар БХЗ-ын бүх арилжааг хийх:* Боловсруулалтын шатанд байгаа ТБҮЦ-ны программ хангамж ашиглалтанд орсноор банкууд сүлжээгээр ТБҮЦ-ны анхдагч болон хоёрдагч захын арилжаа, репо зэргийг хийх боломжтой болж БХЗ-ын арилжаа хурдан шуурхай хийгдэх юм. Дээрх арилжаануудаас гадна БХЗ дээр хийгдэх бусад арилжаануудыг энэхүү сүлжээгээр хийх бололцоотой болгосноор БХЗ идэвхжихэд түлхэц болно.
- *Жигнэсэн дундаж хүүг нийтлэх:* БХЗ-ын жигнэсэн дундаж хүүгийн мэдээг нийтэлснээр арилжаанд оролцогчдыг дэмжих болно. Банк хоорондын арилжааны жигнэсэн дундаж хүүг сард 2 удаа ЗБН тооцох хугацаатай ижил хугацаанд нийтлэх нь БХЗ-д оролцогчид арилжааны шийдвэр гаргахад хялбар болно. Олон улсын БХЗ дээр хэрэглэгддэг LIBOR хүүг 7 хоног, 1 сар, 2 сар, 3 сар, 6 сар, 9 сар, 1 жилээр тус тус тооцон гаргадаг. Монголын хувьд БХЗ дээр хийгдэж буй ихэнх арилжаа 1-7 хоногийн хугацаатай байдаг ба бусад хугацааных бага тоотой хийгддэгээс хугацаагаар ангилахгүйгээр, бүх арилжааны жигнэсэн дундаж хүүг нийтлэх нь тохиромжтой юм.